



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 06

Шарга

┌ 2015 оны төсөвт тодотгол, нэмэлт ┐
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол улсын сангийн сайдын 2012 оны 238 тоот тушаал, Аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус XI хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ИТХ-ын ээлжит IX хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Засаг даргын Тамгын газрын 2015 зардлын төсвийг 2014 оны давсан орлогын 17753000 төгрөг, 2014 оны төсвийн хэмнэлтийн 9736800 төгрөг, нийт 27489800 төгрөгөөр тодотгож Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд -6653000 төгрөг, Урсгал засварын зардалд- 9347200 төгрөг, Мэдээлэл сурталчилгааны зардалд -2200000 төгрөг, Гэрээтийн ажлын цалингийн зардалд – 900000 төгрөг, Зочин төлөөлөгч хүлээн авах зардалд -2000000, Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худалдан авах зардалд -1000000 төгрөг, Төсвийн урамшуулалын зардалд-3000000 төгрөг, Тээвэр шатахууны зардал- 2389600 төгрөгийг тусган баталсугай.

2. Давсан орлогоор хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнг 1 дүгээр хавсралтаар, Төсвийн хэмнэлт, урамшууллаар хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. 2015 онд Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг 19703500 төгрөгөөр тодотгож, 2015 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

4. 2015 онд Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөрөнгө оруулалт, төсвийг тодотгож 4 дугаар хавсралтаар баталсугай.

5. Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын 05, 06 дугаар хавсралтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу үр дүнтэй захиран зарцуулж хэрэгжилт, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг Төсвийн ерөнхий менежер /Т.Мөнхбаяр /, нягтлан бодогч /Ж.Пүрэвжав/ нарт даалгасугай.

7. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаад үүрэг болгосугай

ДАРГА

Ч.АЗБАЯР